БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

## 2022 | VIII


www.facebook.com/StatisticBayangol
www.ubstat.mn
www.1212.mn

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2022
8 сар

Улаанбаатар хот
2022 он

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- \- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

| | |
|---|---|
| мянга | =1000 |
| сая | $=10^6$ |
| тэрбум | $=10^9$ |
| их наяд | $=10^{12}$ |
| мян. | мянга |
| % | хувь |
| мм | миллиметр |
| см | сантиметр |
| дм | дециметр |
| м | метр |
| км | километр |
| $м^2$ | метр квадрат |
| $дм^2$ | дециметр квадрат |
| $км^2$ | километр квадрат |
| $м^3$ | метр куб |
| га | гектар |
| мл | миллилитр |
| л | литр |
| г | грамм |
| кг | килограмм |
| цн | центнер |
| т | тонн |
| Вт | ватт |
| кВт.ц | киловатт цаг |
| кал | калори |
| ккал | килокалори |
| Гкал | гигакалори(=$10^9$ калори) |
| с | секунд |
| мин | минут |
| $мкг/м^3$ | микрограмм метр куб |
| м/с | метр секунд |
| ш | ширхэг |
| х.д.х | хэвлэлийн даралтат хуудас |

# АГУУЛГА


| | Хуудасны дугаар |
|---|---|
| ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 2 |
| НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР | 3 |
| ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ | 4 |
| НИЙГМИЙН ДААТГАЛ | 6 |
| ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 9 |
| ГЭМТ ХЭРЭГ | 12 |
| ДҮҮРГИЙН ТӨСӨВ | 18 |
| ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ | 21 |
| АЖ ҮЙЛДВЭР | 31 |
| ЦАГ УУР, АГААРЫН ОРЧИН | 36 |

I-VIII/2022 Тархаасан: 2022 оны 09 дүгээр сарын 20

ХҮСНЭГТ 1. БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2019 I-VIII | 2020 I-VIII | 2021 I-VIII | 2022 I-VIII |
|---|---|---|---|---|---|
| Шинээр төрсөн хүүхэд | тоо | 3 485 ↓1.6 | 3 321 ↓4.7 | 3 221 ↓3.0 | 2 563 ↓20.4 |
| Амаржсан эхийн тоо | Тоо | 3 435 ↓2.0 | 3 278 ↓4.6 | 3 201 ↓2.3 | 2 547 ↓20.4 |
| Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст | Хүн | 1 199 ↑2.0[1] | 1 101 ↓8.2 | 532 ↓51.7 | 713 ↑34.0 |
| Халдварт өвчнөөр өвчилсөн хүн | Тоо | 1 931 ↑5.2 | 1 152 ↓40.3 | 16 771 ↑14.6[1] | 23 773 ↑41.8 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | Тоо | 2 427 ↓22.3 | 1 833 ↓24.5 | 1 516 ↓17.3 | 3 417 ↑2.3[1] |
| Валютын зах зээлийн ханш, сарын эцэст | 1US$=₮ | 2 672.9 ↑8.4 | 2 849.0 ↑6.6 | 2 849.0 =0.0 | 3 185.7 ↑11.8 |
| Дүүргийн төсвийн орлого | Тэрбум төгрөг | 60.9 ↑19.6 | 67.2 ↑10.3 | 69.5 ↑3.4 | 74.6 ↓7.3 |
| Дүүргийн төсвийн зарлага | Тэрбум төгрөг | 52.3 ↑17.0 | 63.7 ↑21.8 | 58.3 ↓8.5 | 75.0 ↑28.6 |

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан ↑, ↓ эерэг өөрчлөлтийн хувь;
↑, ↓ сөрөг өөрчлөлтийн хувь;
= тогтвортой
[1]-дахин их

ХҮСНЭГТ 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр, эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих Нэгж | 2021 I-VIII | | | | | 2022 I-VIII | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | |
| **Хүн амын нягтрал** /нэг кв км-т ногдох хүн/ | Тоо | 322 | Баянгол | 7 935 | Налайх | 57 | 330 | Баянгол | 8 082 | Налайх | 57 |
| | | | Чингэлтэй | 1 709 | Багануур | 48 | | Чингэлтэй | 1 698 | Багануур | 48 |
| | | | Сүхбаатар | 699 | Багахангай | 32 | | Сүхбаатар | 698 | Багахангай | 32 |
| **Нялхсын нас баралт** /амьд төрсөн 1000 хүүхдэд/ | 0\00* | 11 | Налайх | 21 | Сүхбаатар | 9 | 12 | Багахангай | 18 | Хан-Уул | 9 |
| | | | Багануур | 18 | Хан-Уул | 6 | | Сонгинохайрхан | 14 | Баянгол | 7 |
| | | | Сонгинохайрхан | 12 | Багахангай | - | | Баянзүрх | 10 | Багануур | 6 |
| 10 000 хүн тутмаас **халдварт өвчнөөр өвчлөгсөд** | 0\000 | 954 | Хан-Уул | 822 | Багануур | 538 | 1 150 | Багахангай | 2 448 | Сүхбаатар | 887 |
| | | | Баянзүрх | 805 | Сонгинохайрхан | 488 | | Налайх | 2 039 | Чингэлтэй | 709 |
| | | | Сүхбаатар | 778 | Багахангай | 399 | | Хан-Уул | 1 221 | Сонгинохайрхан | 612 |
| **Төсвийн орлого, зарлагын харьцаа** зарлага=100 | тоо | 98 | Чингэлтэй | 117 | Багануур | 16 | 92 | Баянзүрх | 197 | Чингэлтэй | 93 |
| | | | Хан-Уул | 63 | Налайх | 16 | | Хан-Уул | 125 | Налайх | 66 |
| | | | Сүхбаатар | 59 | Багахангай | 8 | | Багануур | 108 | Багахангай | 26 |
| 16-аас дээш насны 10 000 хүнд ногдох **Гэмт хэрэг** | тоо | 97 | Сүхбаатар | 131 | Налайх | 67 | 182 | Сүхбаатар | 257 | Налайх | 99 |
| | | | Баянзүрх | 102 | Багануур | 54 | | Баянгол | 221 | Багануур | 80 |
| | | | Чингэлтэй | 102 | Багахангай | 50 | | Чингэлтэй | 194 | Багахангай | 51 |

## Ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 713 болж, өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өслөө

Дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2022 оны 8 дугаар сард 713 болж, өмнөх оны мөн үеэс 181 (34.0%) хүнээр өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 380 (53.3%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны ангилалаар, жил бүрийн 8 дугаар сард

| Үзүүлэлт | | 2021-VIII | | 2022-VIII | |
|---|---|---|---|---|---|
| | | Бүгд | Эмэгтэй | Бүгд | Эмэгтэй |
| | | тоо | | | |
| Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд | | 669 | 331 | 678 | 346 |
| Тухайн сард нэмэгдсэн ажилгүйчүүд | | 265 | 147 | 214 | 126 |
| Тухайн сард бүртгэлээс хасагдсан | | 402 | - | 179 | - |
| Үүнээс: Ажилд зуучлагдсан | | 50 | - | 30 | - |
| Тухайн сарын эцэст байгаа ажил хайгч иргэн | | 532 | 273 | 713 | 380 |
| Үүнээс: Насны ангиллаар | 15-24 | 42 | 21 | 24 | 8 |
| | 25-34 | 204 | 100 | 286 | 154 |
| | 35-44 | 172 | 98 | 264 | 136 |
| | 45-54 | 84 | 43 | 118 | 77 |
| | 55-59 | 26 | 10 | 20 | 5 |
| | 60+ | 4 | 1 | 1 | - |

ЗУРАГ 1. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 8 дугаар сард




Бүртгэлтэй нийт ажил хайгч иргэний 24 (3.4%) нь 15-24 насны, 286 (40.1%) нь 25-34 насны, 264 (37.0%) нь 35-44 насны, 118 (16.6%) нь 45-54 насны, 20 (2.8%) нь 55-59 насны, 1 (0.2%) нь 60-аас дээш насны хүмүүс байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 13 (1.8%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд үүнээс 6 (46.1%) нь эмэгтэйчүүд байна.

Дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албанд 2022 оны 8 дугаар сард 214 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 30 иргэн ажилд зуучлагдан орж, 179 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

2022 оны 8 дугаар сард 214 ажилгүй иргэн шинээр бүртгүүлснээс 13 (6.1%) нь сургууль төгсөөд ажилгүй байгаа, 8 (3.7%) нь шилжин суурьшсан, 191 (89.3%) нь ажлаас чөлөөлөгдсөн буюу халагдсан, үлдсэн 2 (0.9%) нь бусад шалтгаанаар ажил хайж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН, АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн 8 дугаар сард



| | Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд | Ажилд зуучлагдан орсон иргэд |
|---|---|---|
| 2021 – VIII | 265 | 50 |
| 2022 – VIII | 214 | 30 |

Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.2 хувиар, ажилд зуучлагдан орсон иргэд 40.0 хувиар тус тус буурчээ.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар, 2022 оны 8 дугаар сард





| | | | |
|---|---|---|---|
| 188 (26.4%) | 481 (67.5%) | 26 (3.6%) | 2 (0.3%) |
| Бүрэн дунд | Дипломын болон бакалаврын дээд | Тусгай мэргэжлийн дунд | Суурь |
| 4 (0.6%) | 9 (1.2%) | 1 (0.1%) | 2 (0.3%) |
| Магистр, Доктор | Техникийн болон мэргэжлийн анхан шат | Боловсролгүй | Бага |

2022 оны 8 дугаар сарын эцэст бүртгэлтэй байгаа ажил хайгч иргэдийн 26.4 хувийг бүрэн дунд, 67.5 хувийг дипломын болон бакалаврын дээд, 3.6 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.2 хувийг техникийн болон мэргэжлийн анхан шат, 0.6 хувийг магистр, доктор, 0.3 хувийг суурь боловсролтой, 0.3 хувийг бага боловсролтой 0.1 хувийг боловсролгүй иргэд тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Ажилгүй хүн: Сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Ажил хайж байгаа: Сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Эх үүсвэр: Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн сарын мэдээ

## Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 84.7 хувиар, нийгмийн даатгалын зарлага 23.1 хувиар тус тус өсжээ

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн сан нийт 270.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 123.9 (84.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
|---|---|---|---|
| | сая төгрөг | | хувь |
| **Нийт орлого** | **146 232.9** | **270 148.0** | **184.7** |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 131 756.3 | 196 243.6 | 148.9 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 6 773.9 | 17 556.7 | 2.6[1] |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | - | 36 157.2 | - |
| ҮОМШӨ[2]-ний даатгалын сангийн | 6 391.4 | 13 925.9 | 2.2[1] |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 1 311.3 | 6 264.6 | 4.8[1] |
| **Нийт зарлага** | **134 778.5** | **165 950.4** | **123.1** |
| Тэтгэврийн даа тгалын сангийн | 115 596.7 | 147 076.6 | 127.2 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 13 439.8 | 11 925.9 | 88.7 |
| ҮОМШӨ[2]-ний даатгалын сангийн | 920.0 | 1 088.1 | 118.3 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 4 822.0 | 5 859.8 | 121.5 |

[1]-дахин

[2]-Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 4. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар




Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 72.6 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.2 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 6.5 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 2.2 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд, эрүүл мэндийн даатгалын санд 13.4 хувь нь тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 5. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар




Нийгмийн даатгалын сангаас 2022 оны 8 дугаар сарын байдлаар даатгуулагч иргэдэд 166.0 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.2 (23.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 88.6 хувийг тэтгэврийн, 0.7 хувийг ҮОМШӨ-ний, 7.2 хувийг тэтгэмжийн, 3.5 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГУУДЫН ЗАРЛАГА, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | Тэтгэвэр, тэтгэмж авагчид | | | Олгосон тэтгэвэр, тэтгэмж | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
| | тоо | | хувь | сая төгрөг | | хувь |
| **НД-ын сангийн нийт зарлага** | **50 320** | **52 917** | **105.2** | **134 778.5** | **165 950.4** | **123.1** |
| **Тэтгэврийн даатгалын сан** | **29 850** | **31 168** | **104.4** | **115 596.7** | **147 076.6** | **127.2** |
| Өндөр насны | 23 099 | 24 241 | 104.9 | 93 910.3 | 117 452.9 | 125.1 |
| Тахир дутуугийн | 4 002 | 4 091 | 102.2 | 9 893.0 | 13 769.0 | 139.2 |
| Тэжээгчээ алдсаны | 1 053 | 1 089 | 103.4 | 2 612.2 | 3 827.7 | 146.5 |
| Цэргийн тэтгэвэр | 1 696 | 1 747 | 103.0 | 9 181.2 | 12 027.0 | 131.0 |
| **Тэтгэмжийн даатгалын сан** | **17 929** | **19 409** | **108.3** | **13 439.8** | **11 925.9** | **88.7** |
| Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж | 12 288 | 15 249 | 124.0 | 2 360.8 | 2 681.8 | 113.6 |
| Жирэмсэн, амаржсаны тэтгэмж | 5 569 | 4 103 | 73.7 | 11 006.9 | 9 190.0 | 83.5 |
| Оршуулгын тэтгэмж | 72 | 57 | 79.2 | 72.1 | 54.1 | 75.0 |
| **ҮОМШӨ*-ний даатгалын сан** | **276** | **274** | **99.3** | **920.0** | **1088.1** | **118.3** |
| Тахир дутуугийн тэтгэмж | 190 | 171 | 90.0 | 664.9 | 863.0 | 129.8 |
| Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 34 | 22 | 64.7 | 214.0 | 143.7 | 67.1 |
| Тэтгэмж, төлбөр | 51 | 69 | 135.3 | 40.4 | 79.1 | 195.8 |
| ҮОМШӨ*-ний сувилал | 1 | 12 | 12.0[1] | 0.7 | 2.3 | 3.3[1] |
| **Ажилгүйдлийн даатгалын сан** | **2 265** | **2 066** | **91.2** | **4 822.0** | **5 859.8** | **121.5** |
| Ажилгүйдлийн тэтгэмж | 2 265 | 2 066 | 91.2 | 4 822.0 | 5 859.8 | 121.5 |

1-дахин

2-Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Оны эхний 8 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас 52917 хүнд 165950.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 31168 хүнд 147076.6 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 19409 хүнд 11925.9 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 2066 хүнд 5859.8 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 274 хүнд 1 088.1 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 31168 хүнд 147.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 79.8 хувийг өндөр настны, 9.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.6 хувийг тэжээгчээ алдсаны, 8.2 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчийн 79.8 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1166 (3.9%) хүнээр, 23.5 (25.0%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс нийт тэтгэмж авагчийн тоо 5438 (38.9%) хүнээр, өсөж, олгосон тэтгэмжийн хэмжээ 1513.9 (11.2%) сая төгрөгөөр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

*Даатгуулагч:* Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

## Нийт мэндэлсэн хүүхэд 2563 болж, өнгөрсөн оны мөн үеэс 20.4 хувиар буурсан байна

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар 2547 эх амаржиж, 2563 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 654 (20.4%), мэндэлсэн хүүхэд өмнөх оны мөн үеэс 658 (20.4%) хүүхдээр тус тус буурсан байна. Амьгүй төрөлтийн 17 тохиолдол бүртгэгджээ. Нийт амаржсан эхчүүдийн 6 (0.2%) нь гэртээ төрсөн байна.

ХҮСНЭГТ 6. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | 2020 I-VIII | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
|---|---|---|---|---|
| | тоо | | | хувь |
| Амаржсан эхийн тоо | 3 278 | 3 201 | 2 547 | 79.6 |
| Амьд төрсөн хүүхэд | 3 321 | 3 221 | 2 563 | 79.6 |
| Нас барсан хүн | 557 | 725 | 632 | 87.2 |
| Эхийн эндэгдэл | - | 4 | 1 | 25.0 |
| Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд | 30 | 30 | 19 | 63.3 |
| 1-5 настай хүүхдийн эндэгдэл | 3 | 2 | 7 | 3.5[1] |
| Амьгүй төрөлт | 9 | 20 | 17 | 85.0 |
| Гэрийн төрөлт | 6 | 6 | 6 | 0.0= |
| Хяналтгүй төрөлт | 3 | 1 | 29 | 29.0[1] |

[1]-дахин

0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 26 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд нас баралт 632 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 93 (12.8%) хүнээр буурчээ.

## *Халдварт өвчин*

Тус дүүрэгт 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар халдварт өвчин 23773 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7002 (41.8%) тохиолдлоор өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



Нийт халдварт өвчний дийлэнх буюу 97.6 хувийг цочмог халдварт өвчин буюу коронавируст халвдар Ковид-19 өвчлөл эзэлж байна. Халдварт өвчний тохилдол нэмэгдэх шалтгаан нь коронавирусын халдвар Ковид-19 өвчлөлтэй холбоотой.

ХҮСНЭГТ 7. ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | 2020 I-VIII | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
|---|---|---|---|---|
| | тоо | | | хувь |
| **Халдварт өвчин бүгд** | **1 152** | **16 771** | **23 773** | **141.8** |
| **Цочмог халдварт өвчин** | **510** | **16 185** | **23 191** | **143.3** |
| Цусан суулга | 220 | 22 | 68 | 3.1[1] |
| Улаан эсэргэнэ | 22 | 1 | 4 | 4.0[1] |
| Менингококкт халдвар | - | - | - | - |
| Гепатит | 20 | 6 | 7 | 116.7 |
| Салхин цэцэг | 130 | 2 | 114 | 57.0[1] |
| Гахай хавдар | 5 | - | 1 | - |
| Сальмонеллёз | 24 | 3 | 9 | 3.0[1] |
| Бруцеллёз | 1 | - | - | - |
| Хүнсний гаралтай бактерт хордлого | 19 | - | 4 | - |
| Ёлом | 6 | - | - | - |
| Нярайн халдвар | - | - | - | - |
| Гар хөл амны өвчин | - | - | - | - |
| Улаанууд | - | - | - | - |
| Энтервирүст цэврүүт фарингит | 25 | - | 69 | - |
| Эритема | 1 | - | - | - |
| Аскариаз | - | - | - | - |
| Энтеробиоз | - | - | - | - |
| Энтеровирүст халдвар тодорхойгүй | - | - | - | - |
| Арьсны халдварт өвчин (exanthema subitum) | - | - | - | - |
| Хачигт рикетикоз | 4 | - | - | - |
| Спирохетээр сэдээгдсэн бусад халдвар | - | - | 3 | - |
| Ковид-19 | 33 | 16 151 | 22 912 | 141.9 |
| **БЗХӨ бүгд** | **458** | **421** | **467** | **110.9** |
| Тэмбүү | 314 | 318 | 308 | 96.9 |
| Төрөлхийн тэмбүү | - | - | - | - |
| Заг хүйтэн | 90 | 50 | 75 | 150.0 |
| Трихомониаз | 54 | 53 | 83 | 156.6 |
| Мөөгөнцөр | - | - | 1 | - |
| Шинээр илэрсэн сүрьеэ | 184 | 165 | 115 | 69.7 |

[1]-дахин
[2]-Бэлгийн замын халдварт өвчин

Цочмог халдварт өвчний 98.8 хувийг коронавирусийн халдварт Ковид-19, үлдсэн 1.2 хувийг цусан суулга, улаан эсэргэнэ, гепатит, салхин цэцэг, гахай хавдар, сальмонеллёз, хүнсний

гаралтай бактерт хордлого, энтервирүст цэврүүт фарингит, спирохетээр сэдээгдсэн бусад халдвар өвчин тус тус эзлээд байна.

10.0 мянган хүн тутмаас  халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1016.2 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 281.9 продицмилээр өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үеэс тэмбүү өвчин 10 (3.1%) тохиолдлоор буурсан бол заг хүйтэн өвчин 25 (50.0%), трихомониаз өвчин 30 (56.6%) тохиолдлоор тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Сүрьеэ өвчин 50 (30.3%), тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлттэй байна. 10.0 мянган хүн тутмын 13 нь тэмбүү, 3 нь заг хүйтэн, 4 трихомониаз өвчнөөр өвчилж байна.

Мөн энэ хугацаанд Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэгт 4222 иргэн хэвтэн эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1044 (32.9%) хүнээр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эх үүсвэр:

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын сарын мэдээ

## Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 1901 (2.3 дахин) хэргээр өссөн байна

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт 3417 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1901 (2.3 дахин) хэргээр өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 52.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өсжээ.

Өнгөрсөн оны мөн үеэс дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг 2.3 дахин өссөн сөрөг үзүүлэлтэд залилангийн гэмт хэрэг 1072-оор (2.6 дахин), хулгайн хэрэг 319-өөр (2.1 дахин), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 29-өөр (2.0 дахин), бусад гэмт хэрэг 199-өөр (2.2 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 226-аар (1.8 дахин) тус тус өссөн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Төрөл | | 2020 I-VIII | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
|---|---|---|---|---|---|
| | | тоо | | | хувь |
| **Нийт гэмт хэрэг** | | **1 833** | **1 516** | **3 417** | **2.3**[1] |
| Гэмт хэргийн төрөл | Хүнийг алах | 9 | 7 | 7 | 0.0[=] |
| | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 27 | 8 | 16 | 2.0[1] |
| | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 438 | 296 | 522 | 176.4 |
| | Хүчиндэх | 20 | 13 | 32 | 2.5[1] |
| | Хулгайлах | 384 | 290 | 609 | 2.1[1] |
| | Дээрэмдэх | 58 | 30 | 59 | 2.0[1] |
| | Залилах | 652 | 676 | 1 748 | 2.6[1] |
| | ХАБТХАЖЭ[2] | 28 | 30 | 59 | 2.0[1] |
| | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | 1 | - | - | - |
| | Булаалт | - | - | - | - |
| | Бусад | 216 | 166 | 365 | 2.2[1] |

[1]-дахин

[2]-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Бүртгэгдсэн гэмт хэргийн 51.2 хувийг залилан, 17.8 хувийг хулгайн, 15.3 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 1.7 хувийг дээрмийн, 0.5 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.7 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 0.9 хувийг хүчин, 0.2 хувийг хүнийг алах, 10.7 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 51.2 хувийг залилангийн гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 1072 хэргээр (2.6 дахин) өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3253 (95.2%) нь хөнгөн хэрэг, 164 (4.8%) нь хүнд хэрэг байна.

Нийт бүртгэгдсэн 3417 гэмт хэргээс 1829 (53.5%) нь цагдаагийн I хэлтэст, 1588 (46.5%) нь цагдаагийн II хэлтэст бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 9. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, хэлтсээр, 2022 оны жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Төрөл | | Бүгд | Үүнээс: Цагдаагийн I хэлтэс | Үүнээс: Цагдаагийн II хэлтэс |
|---|---|---|---|---|
| | | тоо | | |
| **Нийт гэмт хэрэг** | | **3 417** | **1 829** | **1 588** |
| Хэргийн ангилал | Хөнгөн | 3 253 | 1 747 | 1 506 |
| | Хүнд | 164 | 82 | 82 |
| Гэмт хэргийн төрөл | Хүнийг алах | 7 | 3 | 4 |
| | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 16 | 7 | 9 |
| | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 522 | 296 | 226 |
| | Хүчиндэх | 32 | 21 | 11 |
| | Хулгайлах | 609 | 322 | 287 |
| | Дээрэмдэх | 59 | 31 | 28 |
| | Залилах | 1 748 | 945 | 803 |
| | ХАБТХАЖЭ[2] | 59 | 31 | 28 |
| | Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах | - | - | - |
| | Бусад | 365 | 173 | 192 |

[2]-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт 381 (11.2%) гэмт хэрэг гарсан нь хамгийн их байсан бол, хамгийн бага нь 10, 21, 23 дугаар хороодод үйлдэгдээд байна.

ЗУРАГ 7. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар



ХҮСНЭГТ 10. НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, хороо, төрлөөр, 2022 оны жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Хороо | Нийт | Хүн амь | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Хүчин | Хулгай | Дээрэм | Залилан | ХАБТХАЖЭ[2] | Бусад | Танхайрах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | | | | | | | | | | |
| **Бүгд** | 3 417 | 7 | 20 | 522 | 32 | 609 | 59 | 1 748 | 59 | 361 | - |
| I хороо | 113 | - | - | 13 | 1 | 15 | 2 | 71 | 3 | 8 | - |
| II хороо | 238 | - | - | 17 | 3 | 45 | 2 | 141 | 2 | 28 | - |
| III хороо | 204 | - | 1 | 30 | 1 | 27 | 3 | 104 | 6 | 32 | - |
| IV хороо | 332 | - | - | 25 | 2 | 25 | 3 | 254 | 3 | 20 | - |
| V хороо | 138 | - | - | 26 | 1 | 36 | 3 | 37 | 4 | 31 | - |
| VI хороо | 130 | - | - | 32 | 1 | 28 | 4 | 39 | 4 | 22 | - |
| VII хороо | 381 | - | 3 | 29 | 2 | 25 | 4 | 291 | 4 | 23 | - |
| VIII хороо | 87 | 1 | 2 | 22 | 1 | 22 | 3 | 18 | 2 | 16 | - |
| IX хороо | 85 | - | - | 23 | 1 | 22 | 1 | 28 | 2 | 8 | - |
| X хороо | 42 | 1 | - | 8 | 1 | 15 | - | 13 | 1 | 3 | - |
| XI хороо | 139 | - | 1 | 19 | 2 | 27 | 4 | 59 | 7 | 20 | - |
| XII хороо | 109 | 1 | 2 | 18 | 2 | 29 | 4 | 45 | - | 8 | - |
| XIII хороо | 77 | - | - | 11 | - | 21 | 3 | 26 | 4 | 12 | - |
| XIV хороо | 158 | - | - | 34 | - | 39 | 2 | 66 | 2 | 15 | - |
| XV хороо | 106 | - | - | 15 | 1 | 21 | 1 | 60 | 1 | 7 | - |
| XVI хороо | 152 | 1 | - | 31 | 3 | 35 | 1 | 71 | 2 | 8 | - |
| XVII хороо | 169 | - | - | 30 | 4 | 17 | 1 | 96 | 1 | 20 | - |
| XVIII хороо | 140 | - | 1 | 29 | 2 | 17 | 3 | 72 | 2 | 14 | - |
| XIX хороо | 111 | - | 1 | 24 | - | 15 | - | 63 | 2 | 6 | - |
| XX хороо | 228 | 2 | 3 | 35 | 1 | 63 | 4 | 67 | 4 | 49 | - |
| XXI хороо | 41 | - | 1 | 7 | - | 15 | 2 | 12 | - | 4 | - |
| XXII хороо | 82 | - | 1 | 21 | 1 | 13 | 5 | 37 | 1 | 3 | - |
| XXIII хороо | 39 | 1 | - | 2 | 1 | 6 | 1 | 27 | 1 | - | - |
| XXIV хороо | 69 | - | - | 13 | - | 16 | 2 | 33 | 1 | 4 | - |
| XXV хороо | 47 | - | - | 8 | 1 | 15 | 1 | 18 | - | 4 | - |

[2]-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Хороодод гарсан гэмт хэргийн өсөлт, бууралтыг харвал өмнөх оны мөн үеэс хороодод 13.2%-иас 3.5 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

## *Зам тээврийн осол, зөрчил*

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар дүүргийн хэмжээнд нийт ослын шинжтэй 10570 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4398 (2.4 дахин) дуудлагаар өссөн сөрөг үзүүлэлттэй байна.  Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 133 (10.7%) нь гэмт хэргийн шинжтэй , 89.8 хувь нь захиргааны шинжтэй  гомдол, мэдээлэл байна.

ЗУРАГ 8. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, дүүргээр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар




Улаанбаатар хотод нийтдээ 12629 зам тээврийн осол бүртгэгдсний 3420 (27.1%) нь Баянзүрх, 2113 (16.7%) нь хан-Уул, 2388 (18.9%) нь Сонгинохайрхан, 1932 (15.3%) нь Баянгол, 1780 (14.1%) нь Сүхбаатар, 835 (6.6%) нь Чингэлтэй, 161 (1.3%) нь Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд тус тус бүртгэгдээд байна. Бүртгэгдсэн ослыг өнгөрсөн сарын үзүүлэлттэй харьцуулан авч үзвэл 30.4 хувиар, эд материалын хохиролтой осол 35.4 хувиар тус тус өссөн бол, харин хүн гэмтсэн осол 8.5 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 11. БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, төрлөөр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
|---|---|---|---|
| | тоо | | хувь |
| **Нийт** | **1 630** | **1 932** | **118.5** |
| Эд материалын хохиролтой осол | 1 541 | 1 779 | 115.4 |
| Хүн гэмтсэн осол | 89 | 153 | 171.9 |

Нийт зам тээврийн осол 1932 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 302 (18.5%)-оор өссөн байна. Нийт бүртгэгдсэн зам тээврийн ослын 1779  (92.1%) нь эд материалын хохиролтой осол, 153 (7.9%) нь хүн гэмтсэн осол тус тус эзэлж байна. Мөн 3 хүн газар дээрээ нас барсан байна.

Оны эхний 8 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн зам тээврийн ослын 1433 (74.2%) хэргийг даатгалд шилжүүлж, 248 (12.8%) хэрэгт акт тавьж, 37 (1.9%) хэргийг өргөдлийг хүлээн авч ажилласан.

2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар зам тээврийн ослын улмаас нийт 160 хүн бэртэж үүнээс 3 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулан үзвэл нийт бэртсэн хүн 63 (65.0%)-өөр, нас барсан хүн 3 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 12. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС БЭРТСЭН ИРГЭД, төрлөөр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | 2021 I-VIII | 2022 I-VIII | 2022 I-VIII / 2021 I-VIII |
|---|---|---|---|
| | тоо | | хувь |
| **Нийт хохирсон иргэд** | **97** | **160** | **165.0** |
| Хүн гэмтсэн | 96 | 157 | 163.5 |
| Хүн нас барсан | 1 | 3 | 3.0[1] |

[1]-дахин

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Гэмт хэргийн хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохирол гэж ойлгоно.

Хохирлын нөхөн төлбөр: Хохирлын нөхөн төлүүлэлт нь өргөн утгаараа хүний эрх, эрх чөлөөний хэр хэмжээ, учруулсан хор уршигт дүйцэхүйц байх ёстой бөгөөд хохирогчийн эрх, эрх чөлөө, хувийн байдал, гэр бүл, эд хөрөнгө, хөдөлмөр эрхлэлт, сургууль, боловсролын түвшинг аль болох өмнө байсан хэмжээнд нь сэргээхийг ойлгоно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Гэмт хэргийн илрүүлэлт: Хэрэг бүртгэлд бүртгэгдсэн нийт хэргээс мөрдөн байцаалтын явцад гэмт этгээдийг нь тогтоосон хэргийн түвшнээр тодорхойлогдоно.

Зам тээврийн осол: Зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь, нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч, гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно.

Эх үүсвэр:

Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба, Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ

## Дүүргийн төсвийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өсжээ

Дүүргийн төсвийн нийт орлого 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар 74558.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 35892.8 (34.8%) сая төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 96.6 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 3.4 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна.

Татварын орлогын дунд хувь хүний орлогын албан татварын шилжүүлэг хамгийн өндөр буюу 61050.8 (84.8%) сая төгрөгийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 13. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт |
|---|---|---|---|
| | сая төгрөг | | хувь |
| **Нийт орлого** | **110 451.6** | **74 558.8** | **67.5** |
| **1.Татварын орлого** | **107 756.3** | **72 029.8** | **66.8** |
| 1.1 Орлогын албан татвар | 93 938.9 | 61 050.8 | 65.0 |
| Хувь хүний орлогын албан татвар | 93 938.9 | 61 050.8 | 65.0 |
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон | 75 762.8 | 43 280.1 | 57.1 |
| Үйл ажиллагааны орлого | 1 423.2 | 851.6 | 59.8 |
| Хөрөнгийн орлого | 6 790.7 | 4 626.6 | 68.1 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 5 421.6 | 5 795.6 | 106.9 |
| Шууд бус орлого | 4 540.6 | 6 496.9 | 143.1 |
| 1.2 Хөрөнгийн татвар | 6 036.9 | 421.0 | 79.9 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 5 998.0 | 4 789.0 | 79.8 |
| Бууны албан татвар | 38.9 | 31.4 | 80.7 |
| Малд ногдуулах албан татвар | - | 0.6 | - |
| 1.3 Бусад татвар, төлбөр, хураамж | 7 780.5 | 6 158.0 | 79.1 |
| Бусад нийтлэг татвар, төлбөр, хураамж | 2 250.7 | 1 983.6 | 88.1 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 677.7 | 759.0 | 112.0 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1 573.0 | 1 224.6 | 77.9 |
| Газрын төлбөр | 5 529.8 | 4 167.7 | 75.4 |
| Ус, рашаан нөөц ашигласны төлбөр | - | 6.7 | - |
| **2. Татварын бус орлого** | **2 695.3** | **2 529.0** | **93.8** |
| 2.1 Нийтлэг татварын бус орлого | 1 842.1 | 1 730.2 | 93.9 |
| Торгуулийн орлого | 1 647.7 | 1 506.9 | 91.5 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 180.5 | 200.3 | 111.0 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/ | 13.9 | 17.1 | 123.0 |
| Бусад орлого | - | 5.9 | - |
| 2.2 Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 853.2 | 798.8 | 93.6 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 853.2 | 798.8 | 93.6 |

ХҮСНЭГТ 14. ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Биелэлт |
|---|---|---|---|
| | сая төгрөг | | хувь |
| **Нийт зарлага** | **116 928.4** | **74 933.7** | **59.9** |
| Урсгал зардал | 105 634.7 | 70 523.7 | 66.8 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 26 464.2 | 20 321.7 | 76.8 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 8 956.6 | 7 337.7 | 81.9 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1 202.7 | 898.0 | 74.7 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3 715.8 | 2 641.5 | 71.1 |
| Хангамж бараа материалын зардал | 3 609.5 | 2 936.0 | 91.3 |
| Нормативт зардал | 20.3 | 5.7 | 28.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 972.6 | 546.6 | 56.2 |
| Томилолт, зочны зардал | 149.7 | 79.0 | 52.8 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 3 196.4 | 2 339.2 | 73.2 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4 640.6 | 3 538.0 | 76.2 |
| Урсгал шилжүүлэг | 79 170.5 | 50 202.0 | 63.4 |
| Хөрөнгийн зардал | 11 293.7 | 4 410.0 | 39..0 |

Дүүргийн төсвийн нийт зарлага 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар 74933.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 41994.7 (35.9%) сая төгрөгийг зарцуулжээ. Төсвийн нийт зарлагын дунд хамгийн өндөр нь урсгал зардал байна.

ЗУРАГ 9. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөгөөр, жил бүрийн эхний 8 дугаар сарын байдлаар




Дүүргийн төсвийн нийт орлого, зарлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 7.2 хувиар , зарлага 28.4 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 15. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН НИЙТ ӨГЛӨГ, АВЛАГЫН МЭДЭЭ, 2022 оны эхний 8 дугаар сарын байдлаар

| Үзүүлэлт | VII сарын эхний үлдэгдэл | Нэмэгдсэн: тухайн сард үүссэн өглөг | Хасагдсан: тухайн сард төлөгдсөн өглөг | VIII сарын эцсийн үлдэгдэл | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|
| | мянган төгрөг | | | | |
| **НИЙТ ӨГЛӨГ** | **47 879.4** | **4 539.8** | **18 667.1** | **33 752.1** | **100.0** |
| Үндсэн цалин | 13 534.7 | - | 8 890.1 | 4 644.6 | 13.8 |
| Тэтгэврийн даатгал | 15 077.2 | - | 9 111.5 | 5 965.7 | 17.7 |
| Бичиг хэрэг | 100.5 | - | 100.5 | - | - |
| Шуудан, холбоо, интернет | 65.0 | - | 65.0 | - | - |
| Урсгал зардал | 8 602.0 | 4 539.8 | - | 13 141.8 | 38.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10 000.0 | - | - | 10 000.0 | 29.6 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал | 500.0 | - | 500.0 | - | - |

2022 оны эхний 8 дугаар сард 33752.1 мянган төгрөгний өглөг үүсч, үүний дийлэнх буюу 38.9 хувийг урсгал засвар, 29.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 17.7 тэтгэврийн даатгалын зардал, 13.8 хувийг үндсэн цалингийн зардал тус тус эзэлж байна.

<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Орон нутгийн төсөв:</u> Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

<u>Татварын орлого:</u> Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

<u>Татварын бус орлого:</u> Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

<u>Төсвийн орлого:</u> Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

<u>Урсгал зардал:</u> Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

<u>Эх үүсвэр:</u>

Баянгол дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

## Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 14.8 хувиар өслөө

2022 оны 8 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2021 оны жилийн эцэстэй харьцуулахад 10.2 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар




Хэрэглээний үнийн индекс 2022 оны 8 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 10.2 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 10.4 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 5.1 хувь, хувцас, бөс бараа, гутал бүлгийн үнэ 15.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 18.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 9.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 20.7 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 1.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 6.5 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 10.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 9.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 13.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 16. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр, 2022 оны 8 дугаар сард

| Бараа, үйлчилгээний бүлгийн нэр | 2021-VIII / 2020-VIII | 2022-VIII / 2021-VIII | 2022-VIII / 2021-XII | 2022-VIII / 2022-VII |
|---|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **109.1** | **114.8** | **110.2** | **99.6** |
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 112.8 | 120.7 | 110.4 | 95.2 |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 104.1 | 109.4 | 105.1 | 101.9 |
| Хувцас, бөс бараа, гутал | 101.7 | 119.1 | 115.1 | 102.9 |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 108.6 | 114.0 | 118.9 | 101.3 |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 103.0 | 115.4 | 109.9 | 101.4 |
| Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | 107.4 | 129.2 | 120.7 | 100.2 |
| Тээвэр | 118.2 | 106.3 | 103.4 | 99.5 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 100.4 | 102.7 | 101.4 | 100.1 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 101.9 | 107.9 | 106.5 | 101.1 |
| Боловсролын үйлчилгээ | 105.6 | 105.9 | 110.7 | 110.7 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 115.6 | 114.7 | 109.8 | 100.4 |
| Бусад бараа, үйлчилгээ | 106.1 | 120.9 | 113.1 | 101.6 |

2022 оны 8 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 404 нэрийн бараа, үйлчилгээний 30.0 хувийнх нь үнэ өсөж, 12.0 хувийнх нь үнэ буурч, 58.0 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

ХҮСНЭГТ 17. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН САРЫН ИНДЕКС, /зөрэг, сөрөг/

| Бараа, үйлчилгээний бүлэг | Үнийн өөрчлөлт % | Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт |
|---|---|---|
| Хүнсний бараа, согтууруулах бус ундаа | 4.8 | Энэ бүлгийн үнийн бууралтад хүнсний ногооны үнэ 23.2 хувиар, Жимс, жимсгэнэний үнэ 3.3 хувиар, Загас, далайн бүтээгдэхүүний үнэ 1.3 хувиар, Мах, Махан бүтээгдэхүүн үнэ 5.6 хувиар буурсан нь тус тус голлон нөлөөлөв. |
| Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис | 1.9 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд дарсны үнэ 0.9 хувиар, шар айргийн үнэ 2.2 хувиар тус тус шууд нөлөөлөв. |
| Хувцас, бөс бараа, гутал | 2.9 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд бүх төрлийн гутал 2.0 хувиар, Бүх төрлийн хувьцас 3.6 хувиар тус тус голлон нөлөөлөв. |
| Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш | 1.3 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд Орон сууцны урсгал засварын бараа, материал 4.0 хувиар голлон нөлөөлөв. |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 0.4 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл үнэ 3.3 хувиар, Цахиалгаан хэрэгсэлийн засвар 4.0 хувиар тус тус нөлөөлөв. |
| Тээвэр | 0.5 | Энэ бүлгийн үнийн бууралтад хувийн тээврийн хэрэгслийн засвар , үйлчилгээний үнэ 1.6 хувиар, тээврийн хэрэгсэлийн худалдан авалт 0.1 хувиар шууд нөлөөлөв. |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 0.1 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд Мэдээлэл боловсруулах хэрэгсэлийн үнэ 3.1 хувиар шууд нөлөөлсөн байна. |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, бараа үйлчилгээ | 1.1 | Энэ бүлгийн өсөлтөд чөлөөт цагт зориулсан бусад хэрэгсэл 5.0 хувиар, Чөлөөт цаг соёлын үйлчилгээ 2.6 хувиар, Сонин, сэтгүүл, ном, бичгийн хэрэгсэл 1.9 хувиар тус тус нөлөөлөв. |
| Боловсролын үйлчилгээ | 10.7 | Энэ бүлгийн өсөлтөд бага боловсролын үйлчилгээ 7.9 хувиар, дунд боловсролын үйлчилгээ 14.6 хувиар, дээд боловсролын үйлчилгээ 10,9 хувиар, боловсрол олгох бусад үйлчилгээ 7.8 хувиар тус тус нөлөөлөв. |
| Зочид буудал, Нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.4 | Энэ бүлгийн өсөлтөд Нийтийн хоолны үйлчилгээ 0.3 хувиар, Зочид буудал, дотуур байрны үйлчилгээ 4.4 хувиар тус тус нөлөөлөв. |
| Даатгал, Санхүүгийн үйлчилгээ | 0.1 | Энэ бүлгийн өсөлтөд Санхүүгийн үйлчилгээ 0.2 хувиар шууд нөлөөлөв. |
| Бусад бараа, үйлчилгээ | 1.6 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 1.5 хувиар, Хувь хүний бусад эд зүйлс 8.4 хувиар тус тус нөлөөлжээ. |

ЗУРАГ 11. НЭГ ШИРХЭГ ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 8 дугаар сард




ЗУРАГ 12. НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 8 дугаар сард




ЗУРАГ 13. НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 8 дугаар сард






ЗУРАГ 14. НЭГ ЛИТР СҮҮ, ТАРАГИЙН ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, жил бүрийн 8 дугаар сард




2022 оны 8 дугаар сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй хонины ястай махны үнэ өмнөх сартай харьцуулахад 3.5 хувиар, үхрийн ястай мах 1.7 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 18. НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ЖИЖИГЛЭН ХУДАЛДАХ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг, сараар

Үхрийн ястай мах

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2016 | 6 165 | 6 875 | 7 105 | 8 170 | 8 495 | 7 930 | 6 950 | 6 865 | 6 120 | 5 235 | 5 495 | 5 580 |
| 2017 | 6 775 | 7 405 | 7 785 | 7 985 | 8 230 | 7 905 | 7 725 | 7 375 | 7 250 | 6 945 | 6 710 | 6 505 |
| 2018 | 6 615 | 7 110 | 7 740 | 8 365 | 8 465 | 8 735 | 9 085 | 8 225 | 7 780 | 7 845 | 8 005 | 8 305 |
| 2019 | 8 875 | 8 925 | 9 390 | 9 635 | 10 960 | 11 700 | 12 280 | 11 540 | 11 375 | 10 950 | 10 090 | 9 755 |
| 2020 | 10 535 | 11 415 | 11 665 | 11 735 | 11 940 | 12 640 | 12 760 | 11 760 | 11 235 | 10 855 | 11 075 | 11 210 |
| 2021 | 11 615 | 12 605 | 12 670 | 13 850 | 13 960 | 14 770 | 14 800 | 13 700 | 13 420 | 13 280 | 13 345 | 13 495 |
